



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ барилга байгууламжийн жагсаалтаар Эрүүл мэнд, спортын сайдын багцын ХҮ1.1.1.3 Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, хэрлэн сум/-ын ажлын 2, 113,200,000.0 /хоёр тэрбум нэг зуун арван гурван сая хоёр зуун мянга/ төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах, цуцлах, нэмэлт тендер зарлах эрхийг Хэнтий аймгийн Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т үүрэг болгосугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА